

Телевизүүд 2023 оны 1 дүгээр улиралд хөтөлбөртөө дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдал

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, өргөн нэвтрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын ээлжит тайланг гаргалаа.

Тус Хорооноос дохионы хэлний хэлмэрчийн хүрэлцээ хангалтгүй байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрсдийн боломжид тулгуурлан гарган ирүүлж, ирүүлсэн төлөвлөгөөнийхөө дагуу нэвтрүүлгээ дохионы хэл, хадмал тайлбартайгаар гаргах үүргийг хүлээлгэж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад хамрах хүрээтэй, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг өргөн нэвтрүүлгийн 18 телевиз болон мэдээ, мэдээлэл түүнчлэн олон талт хөтөлбөр бүхий арилжааны телевизээс цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийн хэдэн хувийг дохионы хэл, эсхүл хадмал тайлбартай гаргах талаар үе шаттай төлөвлөгөө боловсруулж ирүүлж байна.

Телевизүүдийн хөтөлбөрт 2023 оны 1 дүгээр улиралд дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийг цаг, хувь хэмжээг нэвтрүүлгийн төрөл тус бүрээр гаргалаа.

Энэхүү тайлангаар телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингоос Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагыг хүрээнд үүрэг болгож байгаа телевизүүд өөрийн төлөвлөлтийн дагуу мэдээ мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэл, хадмал тайлбартай хэрхэн нэвтрүүлсэн талаарх дүн мэдээг нэгтгэн гаргасан болно.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 45 телевизээр нийт 2388 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол нийт цагийн 63.6%-д 24 телевизээр мэдээ, мэдээлэл, 8.3%-д 13 телевизээр танин мэдэхүйн нэвтрүүлэг, харин 1.4%-д нь 3 телевизээр хүүхдийн нэвтрүүлгийг тус тус дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна.

2023 оны 1 дүгээр улиралд нийт 45 телевизээр нэвтрүүлсэн дохионы хэлтэй нэвтрүүлгийн дүн

Дохионы хэлтэй нэвтрүүлгийн төрөл	Мэдээ	Нийгэм, улс төр	Танин мэдэхүй	Хүүхэд	Сурталчилгаа	Цэнгээнт	Хүүхэддэйн кино	Соёл урлаг
Нийт цаг	1518:09:57	607:42:42	198:36:31	34:34:08	14:15:04	7:29:41	4:47:53	2:56:41
Нийт дохионы хэлтэй нэвтрүүлэгт эзлэх хувь	63.6%	25.4%	8.3%	1.4%	0.6%	0.3%	0.2%	0.1%

Мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн дүн

Нэвтрүүлгийн төрөл	Телевизийн тоо	Нийт (цаг:мин:сек)	Нийт дохионы хэлтэй гаргасан нэвтрүүлэгт эзлэх хувь
Мэдээ, мэдээлэл	24	1518:09:57	63.6%
Хүүхэд	13	34:34:08	1.4%
Танин мэдэхүй	3	198:36:31	8.3%

Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	24	1518:09:57	63.6%
Хүүхдийн нэвтрүүлэг	3	34:34:08	1.4%
Танин мэдэхүйн нэвтрүүлэг	13	198:36:31	8.3%
Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, зар сурталчилгаа, цэнгээнт,шашин)	45	637:12:01	26.7%

Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
1	MNB Монголын мэдээ	170:04:01
2	NTV	144:44:56
3	UBS	112:28:29
4	Сүлд	104:50:03
5	Live	95:06:17
6	C1	82:28:29
7	MNB	78:57:42
8	Парламент	65:55:26
9	Монгол	65:21:07
10	Volume Plus	65:21:07
11	TB6	63:31:19
12	TB9	59:11:59
13	National times news	58:41:55
14	Авто	55:27:28
15	Суваг 1	43:34:20
16	Талын Монгол	42:46:47
17	TB8	39:35:05
18	TB2	36:57:43
19	SBN	35:47:55
20	TenGer	26:20:16
21	Like	22:52:56
22	Channel 11	22:39:48
23	Хөгжил	16:28:22
24	MNC	8:56:27
	Нийт цаг	1518:09:57
	Нийт дохионы хэлд харьцуулсан	63.6%

Дээрх хүснэгтэд байгаа 24 телевиз өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Өргөн нэвтрүүлгийн 18 телевизээс нийт 9 телевиз мэдээ, мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй бэлтгэн нэвтрүүлсэн байна. 2022 оны эцсийн дүнгээр өргөн нэвтрүүлгийн 11 телевиз мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна.

MNB, MNB Монголын мэдээ, NTV, Сүлд, TB8, C1, Парламент, TB9, Сүлд, Монгол, MNC, SBN телевизүүд 2022 онд мөн мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй нэвтрүүлж байсан телевизүүд юм. Энэ он гараад шинээр TenGer, UBS телевизүүд мэдээ, мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй нэвтрүүлж эхэлсэн бол Авто, National Times News, Like, Суваг 1, Талын Монгол, 2, Channel

11 зэрэг телевизүүд Монголын арилжааны телевизүүдийн Дуун холбоогоороо нэгдэн мэдээллийн хөтөлбөрөө тодорхой хэмжээнд дохионы хэлтэй бэлтгэн нэвтрүүлэх болсон.

Харин ТВ5, 25-р суваг, ETV, Малчин телевизүүд 2022 онд мэдээллийн хөтөлбөрөө дохионы хэлтэй нэвтрүүлж байсан бол энэ оны 1 дүгээр улирлын байдлаар нэвтрүүлээгүй байна.

Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг
1	Like	84:32:33
2	National times news	39:09:48
3	ТВ6	22:30:40
4	Хөгжил	16:53:00
5	Гандан	8:15:10
6	ТМ	7:47:15
7	Мянгат Малчин	5:15:14
8	News Channel	4:18:58
9	Талын Монгол	4:03:55
10	Сүлд	2:59:33
11	Соён гэгээрүүлэгч	1:17:58
12	Суваг 7	0:52:01
13	MNB Гэр бүл	0:40:26
	Нийт цаг	198:36:31
	Нийт дохионы хэлд харьцуулсан	8.32%

Дээрх хүснэгтэд үзүүлсэн 13 телевиз танин мэдэхүй нэвтрүүлгээ тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлснээс Like телевиз эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмжийн нэвтрүүлгээ тогтмол дохионы хэлтэй нэвтрүүлж байгааг онцолж байна. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдээс ТМ, Сүлд телевиз танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлжээ. ТМ телевизийн хувьд мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг бус танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлэх байдлаар дохионы хэлтэй нэвтрүүлэх үүргээ хэрэгжүүлж байна.

Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг
1	Dream TV	23:38:29
2	Боловсрол суваг	8:13:25
3	ETV	2:42:14
	Нийт цаг	34:34:08
	Нийт дохионы хэлд харьцуулсан	1.4%

2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр Dream, Боловсрол, ETV телевиз хүүхдийн хөтөлбөр дохионы хэлтэй нэвтрүүлсэн нь нийт 34 цаг гаруй болж байна. Dream TV телевиз нь хүүхдэд зориулсан төрөлжсөн хөтөлбөртэй цорын ганц телевиз юм.

Телевизүүдээр нэвтрүүлсэн хадмал тайлбартай нэвтрүүлгийн тайлан

Нэвтрүүлгийн төрөл	Мэдээ	Нийгэм улс төр	Танин мэдэхүй	Хүүхэд	Бусад	Нийт цаг
Нийт цаг	22:18:38	150:20:20	89:35:04	21:20:36	2:05:38	285:40:16
Нийт хадмал тайлбартай нэвтрүүлэгт эзлэх хувь	7.8%	52.6%	31.4%	7.5%	0.7%	100%

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 22 телевиз 285 цаг 40 минутын хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Үүнээс С Channel телевиз нийт 22 цагийн өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө, Central телевиз 36 цагийн танин мэдэхүй нэвтрүүлэг, 74 цагийн нийгэм, улс төрийн нэвтрүүлгээ тус тус хадмал тайлбартай нэвтрүүлсэн нь хамгийн олон нэвтрүүлсэн үзүүлэлт болж байна.

Доорх хүснэгтэд нэвтрүүлгээ хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүдийн нийт цагийг нэвтрүүлгийн төрлөөр нь ангилан үзүүлж байна.

Телевизийн нэр	Хадмал тайлбартай нэвтрүүлгийн цаг	Нийт цаг	Нийт хадмал тайлбарт харьцуулсан хувь
Мэдээ мэдээлэл			
С Channel	22:18:38	22:18:38	7.8%
Хүүхдийн нэвтрүүлэг			
National times news	8:15:20	21:20:36	7.5%
Мянгат Малчин	7:58:35		
Dream TV	4:08:29		
Боловсрол суваг	0:58:12		
Танин мэдэхүй			
Central	36:18:03	89:27:50	31.4%
Стар	22:49:21		
Тэнгэр	16:10:30		
Ийгл ньюс	13:49:52		
Авто	0:20:04		
Нийгэм, улс төр			
Central	74:39:10	150:20:20	52.6%
Live	17:43:27		
Мянгат Малчин	17:42:26		
ТВ8	10:45:07		
Стар	8:20:20		
Ийгл ньюс	6:31:22		
Парламент	3:15:17		
25-р суваг	2:06:49		
ТВ5	2:06:46		
М кино	2:00:47		
NTV	1:54:49		
ТВ6	1:15:46		
MNB Гэр бүл	0:59:11		
Channel 11	0:44:46		
MNB	0:14:17		
Бусад			
Гандан	2:05:38	2:05:38	0.7%

Монгол улсад хамрах хүрээтэй мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлдэг энэхүү мэдээлэлд нэр дурдагдаагүй бусад телевизүүд хөтөлбөрөө дохионы хэл эсхүл хадмал тайлбартайгаар нэвтрүүлэх шаардлагатай байна.